



МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМ (ХЭФ)

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ

ХҮНИЙ ЭРХИЙН ТАЙЛАН (UPR)

36 дахь удаагийн чуулган

2020 оны 5 сар

МОНГОЛ УЛС

Сэдэв:

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бэлтгэсэн: “Глоб Интернэшнл төв” ТББ

Холбогдох хаяг:

Цахим хаяг: [hnaran@globeinter.org](mailto:hnaran@globeinter.org); Утас: 976-11-324764; 976-99288924

## ЖЕНЕВ, 2019 оны 10 сар

“Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллага нь 1999 оны 3 дугаар сард Улаанбаатар хотноо байгуулагдсанаас хойш үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиулэн дэмжин ажиллаж буй бөгөөд IFEX, Forum Asia, GFMD олон улсын байгууллагын гишүүн юм.

Цахим хуудас: <https://www.gic.mn/en>, цахим хуудас: [globenews@globeinter.org.mn](mailto:globenews@globeinter.org.mn)

### Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Энэхүү тайланг хэвлэл мэдээллийн төрийн бус байгууллага, сэтгүүл зүйн эрдэмтэн багш, нийслэл, орон нутгийн сэтгүүлчидтэй хийсэн гурван удаагийн Зөвлөлдөх уулзалтад тулгуурлан боловсруулав.

1. Монголын Засгийн газар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чиглэлээр хүлээн авсан 8 зөвлөмжөө (108.131-108.138) өнөө хүртэл хэрэгжүүлээгүй байна.
2. **Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг ИБУТЭОУП-д нийцүүлж, Харилцаа холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах.**

УИХ-аас Харилцаа холбооны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны тавдугаар сарын 30-ны өдөр баталсан боловч зохицуулах байгууллагын бие даасан байдлыг баталгаажуулаагүй.

УИХ нь 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийг хүчингүй болгож, Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай тусдаа гурван хууль батлахаар төлөвлөж, төслүүд нь бэлэн болж байна. Одоо хүчин төгөлдөр байгаа Сонгуулийн тухай хуулийн “Хууль бус сурталчилгааг хориглох” хэмээх 70 дугаар зүйлийн агуулга хуулийн гурван төсөлд хэвээр тусгагдсан байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зайд, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах /70.1.6/, сонгуульд оролцохос татгалзахыг уриалах /70.5.7/, сонгуулийн сурталчилгааны явцад бусдыг гүтгэх, доромжлох, гутаах, хуурамч мэдээ, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр тараах /70.5.13/, Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуульд оролцогч аль нэг талын талаар бүх төрлийн мэдээ, мэдээлэл гаргах, гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно /70.7/

Өнөөгийн Сонгуулийн тухай хуулийн янз бүрийн хэсэгт хэвлэл мэдээлэлд ногдуулах хатуу шийтгэл тусгагдсан. Тухайлбал, Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар хуурамч буюу худал мэдээ, мэдээлэл тараасан, нийтэлсэн, цацсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдвол сонгуульд зарцуулсан хөрөнгийг нь гэм буруутай этгээд нөхөн төлнө /70.8/, Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх энэ хуульд заасан журам зөрчсөн радио, телевизэд нэг удаа сануулах арга хэмжээ авах бөгөөд дахин давтал

санал авах өдөр хүртэл үйл ажиллагааг нь тухайн зөвшөөрлийг олгосон байгууллага зогсооно /82.19/ мөн дээрх заалтуудыг зөрчсөн тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ /82.21/. Сонгуулийн сурталчилгааг интернэт орчин ашиглан явуулахад захиалагчийн нэр, эсхүл тэдгээрийн сонгуулийн штабын нэрийг заавал дурдана гэсэн заалтыг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, аливаа этгээдийг олж тогтоох боломжгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо тухайн цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн санал хураалтын хугацаа дуустал хязгаарлана /83.7/

Засгийн газрын хяналтад байдаг Харилцаа холбооны зохицуулах хороо нь засгийн газрын бүтэц дэх Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох шийдвэр гаргадаг<sup>1</sup>. Энэ нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй гэсэн заалттай зөрчилдэж байна.

### **3. Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн зүйл заалтыг халах**

Эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлохтой холбоотой заалтуудыг халсан ч 2017 оноос мөрдөгдэж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын “Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” хэмээх 14.8 дахь заалтад сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заажээ.

2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн “Гүтгэх” хэмээх 6.21-р заалтад “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчлийн хэргийг цагдаа шалгах эрх мэдэлтэй. Өндөр албан тушаалтантай холбоотой зөрчлийн хэргийг шалгах үүргийг Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах Албад ногдуулжээ.

Торгуулийн хэмжээ нь өндөр. Мөн цагдаагийн байгууллагаас хувь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад давхар нь торгууль ногдуулах боломжтой ба энэ нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай зөрчилдэж байна. Энэ хуулиар хэвлэл мэдээллийн редакц нь нийтлэл, нэвтрүүлгийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

Хууль хэрэгжик эхэлсэн 2017 оны долоодугаар сарын нэгнээс 2019 оны гуравдугаар сар хүртэл 46 сэтгүүлчид гүтгэх зөрчилтэй холбогдуулан хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 12 тохиолдолд сэтгүүлчийг буруутайд тооцож, торгууль оногдуулжээ. Глоб Интернэшнл Төвөөс 2018 оны тавдугаар сараас 2019 оны дөрөвдүгээр сар хүртэлх хугацаанд 300 сэтгүүлчийг хамруулсан хийсэн судалгааны дунд гурван сэтгүүлч тутмын нэг нь Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.21-ээр цагдаагийн байгууллагад дуудагджээ. 2018 оны 12-р сард МСНЭ, Хэвлэлийн Хүрээлэн, Монголын Телевизүүдийн Холбоо, Монголын Өдөр Тутмын Сонины Холбоо, Глоб Интернэшнл Төв зэрэг хэвлэл мэдээллийн 15 төрийн бус байгууллага ХЗДХЯ-ны Ажлын хэсэгт хандан Зөрчлийн тухай хуулийн 6.21 заалтыг хүчингүй болгох мэдэгдэл хүргүүлэв.

<sup>1</sup> Сонгуулийн тухай хуулийн 70.18-р зүйл

УИХ-аас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр болсон бөгөөд 13.4 дэх хэсэгт гүтгэх гэмт хэргийг дор дурдсанаар тусгажээ.<sup>2</sup>

1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг нийтийн сүлжээгээр тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэ зүйлийн Тайлбар: “Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэргээн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй”.

Улс төрч, өндөр албан тушаалтууд нэр төр гутаасан гэх хуулийг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг ашигласаар байна. Гүтгэлгийн хэргийг Эрүүгийн хэргийн шүүхэд хандан давж заалдана. 2018 онд Эрүүгийн хэргийн шүүхээс гүтгэх зөрчлийн талаарх 32 шийдвэрийг хянаснаас 19 шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

2017 оны нэгдүгээр сараас 2019 оны дөрөвдүгээр сарын хооронд нэр хүнд гутаасан хэргээр сэтгүүлчийн эсрэг нийт 19 иргэний нэхэмжлэл гарсан. Шүүхийн мэдээллийн санд олон нийтэд нээлттэй тавигдсан 12 хэргийн нэхэмжлэгчийн 33 хувь нь улс төрийн албан хаагч, өндөр албан тушаалтан байна.

Олон нийтийн эрх ашигт нийцсэн үндэслэл бүхий хамгаалалт нэр төр гутаахтай холбоотой хуулиудад байдаггүй нь гол бэрхшээл юм. Бас нэг асуудал нь эдгээр хуулийн дагуу хуулийн этгээд, тухайлбал хувийн бөгөөд төрийн байгууллага аль аль нь зарга мэдүүлж болно. Иргэний хууль нь тorgуулийн мөнгөн дүнг нэхэмжлэгч санаснаараа тогтоох боломж олгодог бөгөөд хэмжээ нь эрс нэмэгдэж байна.

УИХ-ын гишүүн Б.Ундармаа 2018 оны 6-р сарын 07-нд “Өнөөдөр” сониньг шүүхэд өгсөн байна. Ингэхдээ гүтгэлгийн шинжтэй нийтлэлүүд гаргасан учраас нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд нь халдсан гэж үзэн 100 сая төгрөг нэхэмжилжээ. Тэрбээр “Өнөөдөр” сонинд гарсан “УИХ-ын гишүүн Б.Ундармаа хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ бүртгүүлээгүй компаниа нэхэмжилжээ”, “УИХ-ын гишүүн Б.Ундармаа хуурамч баримтаар гэрчилгээ гаргуулж авсан гэв” гэх нийтлэлүүдийг 42, цахим хуудсанд хэвлэгдсэнийг 15, бусад сайтад дамжин хуулсыг 25, өмгөөлөгчийн хөлсөө найман сая гэж үнэлэн нийт 100 сая төгрөг нэхэмжилжээ. “Өнөөдөр” сонин өөрсдийн бэлтгэн нийтэлсэн материалыудаа баримтаар баталгаажуулсан гэж үзэж буйгаа мэдэгдээд байгаа юм. Тус сонины газрынхан Улсын Дээд Шүүхэд хандсан бөгөөд шийдвэр нь нэхэмжлэгчийн нэр төрийг сэргээж, 5 сая төгрөгийн тorgууль оноохоор болжээ. Тэд одоо Ерөнхий шүүгчид хандан давж заалдахаар төлөвлөж байна. Энэ нь сонинуудад хэрхэн эдийн засгийн дарамт сүрдүүлэг үзүүлж болдгийг харуулж байна. Хэдийгээр шүүхээс тогтоосон тorgуулийн хэмжээ багассан ч шүүхээс нэхэмжлэлийн дүнг бүрэн хангаж болзошгүй гэх өөрийн цензурийг өөгшүүлж буй хэрэг юм<sup>3</sup>.

<sup>2</sup> Хуулийн төсөлтэй дараах линкээр орж танилцана уу. <http://forum.parliament.mn/projects/10659>

<sup>3</sup> Глоб Интернэшил төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, 2018 он.

[https://www.gic.mn/public/docs/freedom\\_report/media\\_freedom\\_report\\_2018\\_mn.pdf](https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2018_mn.pdf)

**4. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчид болон иргэний нийгмийн байгууллагын идэвхтнүүд аливаа хэлбэрийн ял шийтгэлээс ангид үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах боломжийг хангах**

Сэтгүүлчдийн аюулгүй байдлын асуудал онцгой анхаарал татсан хэвээр байна. Глоб Интернэшнл Төвийн тайлан<sup>4</sup> дурдсанаар судалгаанд хамрагдсан 300 сэтгүүлчийн 67 хувь өөрсдөө болон гэр бүлийн хүн нь сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлолд өртжээ. Мөн 58 хувийнх нь ажлын багаж хэрэгсэлд халдсан бол шүүх, хүчний байгууллагын дарамт 36 хувьд нь тохиолджээ. Сэтгүүлчдийн 18 хувьд бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан тохиолдол гарсан байна. Эдгээр зөрчил нь телевиз, цахим сайт, сонинд ажилладаг 35 хүртэлх насын залуу сэтгүүлчдэд илүүтэй тохиолддог ажээ.

2018 оны долоодугаар сард *Ийгл телевизийн сэтгүүлч Б.Батцэцэгийн* биед цагдаагийн албан хаагч халдсан тохиолдол гарсан. Тодруулбал, Улаанбаатар дахь Турк сургуулийн орлогч захирал Турк улсын иргэн Вэйсел Акчайг хулгайлахыг завдсан явдлыг сурвалжилж байх явцад эрүүнд нь цохиж, үсдсэн. Энэ асуудлаар *Ийгл телевиз* нь цагдаагийн байгууллагад гомдолоо гаргасан боловч харамсалтай нь одоо хүртэл хариуцлага тооцоогүй байна<sup>5</sup>.

**5. Сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэл үлээгчдийг хамгаалах**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан сэтгүүлчийн нууц эх сурвалж, шүгэл үлээгчийг хамгаалахаар амласан холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн алхам хийгдээгүй байна. Судалгаанд хамрагдсан 300 сэтгүүлчийн 51 хувь нь нууц эх сурвалжаа илчлэх шаардлагатай тулгарчээ.

**6. Цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулах**

Практик дээр цахим хуудасны сэтгэгдэл үгийн шүүлтүүр ашиглахгүй байгаа ч Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Тоон контентын ерөнхий нөхцөл шаардлага” хүчинтэй, ХЗДХЯ-ны хэм хэмжээний актад бүртгэгдээгүй хэвээр байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2 зүйлээр харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох нөхцөлийг тусгасан байна. Ингэхдээ шүүхийн шийдвэргүйгээр зөвхөн прокурорын зөвшөөрлөөр мөрдөгч нь харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулж авах боломжтой байна.

**7. Эрхийн аливаа хэлбэрийн хязгаарлалтыг хууль ёсны байх, зайлшгүй байх, хэм хэмжээндээ байх зарчимд нийцүүлэх**

<sup>4</sup> Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний мониторингийн тайлан. “Хөнгөлөлтийн ерөнхий систем +”-ээр дамжуулан хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиулэн дэмжих нь” төслийн хүрээнд Глоб Интернэшнл төвийн захиалгаар Монголын Хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран бэлтгэв.

<sup>5</sup> Глоб Интернэшнл төв. Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, 2018 он.

[https://www.gic.mn/public/docs/freedom\\_report/media\\_freedom\\_report\\_2018\\_mn.pdf](https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2018_mn.pdf)

УИХ-аас 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хууль баталсан. Уг хууль 2017 оны есдүгээр сарын нэгнээс хэрэгжиж эхэлснээр Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчингүй болжээ. Шинэ хуулиар Засгийн газар Нууцын журам, Нууц мэдээллийн жагсаалтыг батлах бөгөөд үүний дагуу төрийн байгууллагууд өөрсдөө дотооддоо нууцын журам, нууц мэдээллийн жагсаалтаа батлах болсон. Энэ нь Үндсэн хуулиар задруулж үл болох нууцыг хуулиар тогтоон хамгаалах тухай заалттай зөрчилдэж байгаа юм. Энэ хууль, журам нь хор хохирлын шалгуурыг хангаагүй. Нууц мэдээллийг ил болгох үйл явц гурван сар үргэлжилнэ. Засгийн газраас төрийн нууц мэдээллийг ил болгох эцсийн шийдвэр гаргах бөгөөд үүнээс өмнө төрийн байгууллагууд ил болгох хүсэлтээ Тагнуулын Ерөнхий Газарт илгээнэ. Энэ нь төрийн байгууллагууд бүхий л үйл ажиллагаагаа нууц гэх халхавч дор далдлах боломж олгож байгаа юм<sup>6</sup>. 2017 онд 60 байсан нууц мэдээллийн тоо 2019 онд 565 болон нэмэгджээ.

Мэдээллийг нууцлахдаа үндэсний аюулгүй байдлын хууль ёсны эрх ашигт учруулах жинхэнэ хор хохирлыг хангаагүй, үүнийг олон нийтийн мэдээлэлтэй байх эрх ашигт учрах хор хохиролтой дэнслэн тооцоогүй байна.

МООНРТ-ийн сэтгүүлч Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргатай хийсэн ярилцлагын үеэр “Улаанбаатар хотын кадастрын зургийг олон нийтэд нээлттэй байлгах боломжтой юу?” гэж асуухад “Энэ бол төрийн нууц” хэмээн хариулжээ. Мөн “Нийслэлийн А бүсэд хэн газар эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа” тухай асуухад “хувь хүний нууц”<sup>7</sup> гэсэн байна.

Шаардлагагүй ийм хязгаарлалт эрэн сурвалжлах сэтгүүл зүйд хориг тавьж байна гэж бид үзэж байна.

Эрүүгийн шинэ хуулиар төрийн нууцыг илчилсэн, төрийн нууцад хамаарах мэдээ, баримт эд зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, хадгалсан тохиолдолд гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан.

УИХ-аас 2011 оны 6-р сарын 16-нд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль баталсан. Глоб Интернэшнл төв 2019 оны хоёрдугаар сард энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн<sup>8</sup> бөгөөд төрийн 16 байгууллагаас мэдээлэл хүссэнээс зөвхөн тавд нь бүрэн гүйцэд хариулт авсан юм.

*Улаанбаатар хотын Иргэн Дархан Уул аймгийн ЗДТГ-т хандан агаар, хөрсний бохирдлыг хэмжих төхөөрөмж худалдан авах ажиллагаатай холбоотой тендер, сонгон шалгаруулалт, гэрээний мэдээлэлтэй танилцах хүсэлт илгээжээ. Мэдээлэлд хариу өгөх 14 хоногийн хуулийн хугацаанд мэдээллээ аваагүй иргэн утасдаж, сануулахад иргэнийг өөрийн биеэр ир гэсэн байна.*

Энэ бүхнээс хязгаарлах мэдээллийн хүрээ хэтэрхий өргөн, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бие даасан байгууллага үгүй, төрийн байгууллагууд Мэдээллийн ажилтангүй, мэдээллийн хүсэлтэд хангальтай хариу өгөх хөшүүрэг байхгүй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

## **8. Интернэт зохицуулалтын бүхий л хүрээнд халдашгүй байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамруулан хүнийг эрхийг бүхэлд нь хангах**

<sup>6</sup> Глоб Интернэшнл төв. Мэдээлэл авах эрх ба нууцын хууль тогтоомжийн дүн шинжилгээ. 2019 он.

<sup>7</sup> Мөн тэнд.

<sup>8</sup> Үнэлгээнд FOIA.net арга зүйг ашигласан болно.

[https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2018/11/SDG-Parallel-CS-Report.18.09.20.final\\_.pdf](https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2018/11/SDG-Parallel-CS-Report.18.09.20.final_.pdf)

Интернэт хэрэглэгчдийн IP хаягууд нээлттэй хэвээр байна. Монгол Улсад өгөгдөл хамгаалах хууль үгүй. Хувь хүний нууцын тухай хууль 1995 онд батлагдсанаас хойш нэмэлт өөрчлөлт ороогүй. Хувийн компани, банкууд үйлчилгээндээ хүний хурууны хээ ашиглаж эхэлсэн. Монголын томоохон супермаркетуудын нэг “Номин” хөнгөлөлтийн карт эзэмшигчидээ хурууны хээгээ ашиглахыг санал болгож байна.

Иргэдийн хувийн мэдээллийг алдах, урвуулан ашиглахын эсрэг Засгийн газар хэрхэн хяналт тавих, өгөгдөл ашиглах зөвшөөрөл олгож буй үйл явц хэрхэн явагддаг нь тодорхойгүй байна. Хувийн халдашгүй дархан байдлаа хамгаалах тухай олон нийт мэдлэг, ойлголтгүй.

## 9. Зөвлөмж

Үндсэн хуулийн аравдугаар зүйлд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ сахин биелүүлэхээр тунхагласны дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах талаар хүлээн авсан Зөвлөмжөө хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнээс гадна, дор дурдсан шинэ зөвлөмжүүдийг санал болгож байна.

- 1) Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох
- 2) Олон нийтийн зүтгэлтнүүд нээлттэй шүүмжлэлд хүлээцтэй хандах, олон нийтийн хараа хяналтад байхаар өөрсдөө сонголт хийснийг хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж санаачлах
- 3) Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд хязгаарлалтын хүрээг нарийвчлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бие даасан байгууллага томилох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах,
- 4) Төрийн болон албаны нууцын тухай хуульд хязгаарлалтыг Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын дотоод журмаар бус, гагцхүү хуулиар тогтоохоор өөрчлөн батлах. Ингэхдээ хууль ёсны байх, зайлшгүй байх, хэмжээндээ байх гурван талт шалгуурт тулгуурлах. Нууцын бүх хууль ноцтой хор хохирол учруулах шалгуурт нийцэх, түүнчлэн энэхүү хор хохирол нь олон нийтийн ашиг сонирхлоос илүү чухал байх нөхцөлийг хангасан байх.
- 5) Эрүүгийн хуулийн “Төрийн нууц мэдээллийг хууль бусаар олж авах” хэмээх 19.11 дэх зүйл хэсгийг өөрчлөх
- 6) Өгөгдөл хамгаалах хууль тогтоомж батлах
- 7) Сонгуулийн гурван хуулийн төсөлд одоогоор тусгагдсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой заалтуудыг олон улсын хэмжээнд нийцүүлэн өөрчлөх, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах заалтуудыг хүчингүй болгох